



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

“Алтандуулга” ХК-ийн үнэт цаасны  
бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Увс аймгийн өмч хувьчлалын комиссын 1995 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн, “Алтандуулга” ХК-ийн үнэт цаасны арилжааг Хорооны шийдвэрээр зогсоосон байгааг тэмдэглэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Алтандуулга” ХК-ийн гаргасан нийт 464,891 ширхэг энгийн хувьцаанаас Увс аймгийн өмч хувьчлалын комиссын 1995 оны 08 дугаар тогтоолоор хорогдуулсан нийт 21804 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасч, тус хувьцаат компанийн гаргасан нийт хувьцааг нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 443,087 /дөрвөн зуун дөчин гурван мянга наян долоо/ ширхэгээр тогтоосугай.


2. Тогтоолын 1 дэх заалтын дагуу нийт 21804 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмд холбогдох өөрчлөлт оруулж хувийг Хороонд ирүүлэхийг “Алтандуулга” ХК /Г.Жамьян/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА-2

Д.БАЯРСАЙХАН



000209